

БАТЛАВ. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗРЫН ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

2020 оны 03 сарын 13

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЦЭНХЭРМАНДАЛ СУМАНД УХААЛАГ ХУДАГ /2ш/  
БАЙГУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: **ЦЭНХЭРМАНДАЛ СУМАНД УХААЛАГ ХУДАГ /2ш/  
БАЙГУУЛАХ**

Төслийн дугаар: **ХЭАОНӨГ/202012012**

**ЧИНГИС ХОТ  
2020 ОН**

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.03.16

Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд ухаалаг худаг байгуулах тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг [www.tender.gov.mn-ээг](http://www.tender.gov.mn) банкны меркантийн системийг ашиглан төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар оролцогч өөрийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр **2020 оны 03 сарын 23 өдрийн 09,00 цагаас** өмнө илгээнэ

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 03 дүгээр сарын 23** –ны өдрийн **09:10 цаг**-т нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хэнтий Аймгийн ЗДТГ-н 3-р давхар**  
**Хэнтий аймгийн ОНӨГ**  
**303 тоот өрөө, Утас 70563056**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨЭЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨЭЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан /2018, 2019 он/;</li> <li>- Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого нь 30,0 сая төгрөгөөс багагүй байх /2018, 2019 он/</li> <li>- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ санал болгож буй үнээс багагүй байх /дансны баталгаажсан хуулга эсвэл банкны зээл олгох тухай мэдэгдэл/</li> <li>- Сүүлийн 2 жилийн хэрэгжүүлсэн ижил төстэй гэрээний дүн нь санал болгож буй үнээс багагүй байх /гэрээ, акт ирүүлэх/</li> <li>- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар</li> <li>- Нийлүүлэх барааны бодит зураг, Техникийн тодорхойлолт</li> <li>- Техник, тоног төхөөрөмжийн жагсаалт /өөрийн өмчлөлийн/</li> <li>- Ажил гүйцэтгэх график</li> <li>- Мэргэжилтэй ажилчдын судалгаа, дипломын хуулбар, иргэний үнэмлэхний хуулбар</li> <li>- Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>- Тухайн ажилд хэдэн төгрөгний, ямар нэр төрлийн дотоодод үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан барааг ашиглах тухай мэдээллийг ирүүлнэ./маягт 3-аар ирүүлэх/</li> </ul>
ТӨЭЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: <b>Хэнтий аймгийн ОНӨГ</b></p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.meps.gov.mn">www.meps.gov.mn</a>) хаягаар оролцогч өөрийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээ рилгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn-ээп">www.tender.gov.mn-ээп</a> банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.meps.gov.mn">www.meps.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй</p> <p>Огноо: <b>2020 оны 03 дугээр сарын 23-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 00 минут</b></p>
ТӨЭЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Хэнтий аймгийн ОНӨГ</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>Хэнтий аймгийн ЗДТГ-н байр, 3-р давхар, 304 тоот өрөө</b></p> <p>Огноо: <b>2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 10 минут</b></p>

<b>ТӨЭЗ 2.3</b>	Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>- Татварын цахим тодорхойлолт</li><li>- Харьяа нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</li><li>- Харьяа шүүхийн байгууллагын тодорхойлолт</li><li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт</li></ul>
<b>ТӨЭЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>1 багц</b>

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Барааны тодорхойлолт:** Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

### ШИНЭЭР НЭВТРҮҮЛЭХ “УХААЛАГ ХУДАГ” СИСТЕМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ШААРДЛАГА

#### УХААЛАГ ХУДАГ систем

Үндсэн 4 хэсгээс бүрдэнэ:

1. **Online Server – Мэдээллийн нэгдсэн сан** Худгуудыг удирдлагаар хангах, гуравдагч системүүд холбогдох, худгуудаас мэдээлэл цуглуулах, хуваарилах зэргийг хийж гүйцэтгэх үүрэгтэй. Мөн тайлан, статистик мэдээ боловсруулах, мониторингийн системийн мэдээллээр хангах үүрэгтэй.
2. **Худгийн систем.** Худаг дээрх тоног төхөөрөмж, түүний удирдах програм хангамж
3. **Мониторинг систем.** Диспетчер системийг хянах зориулалт бүхий программ хангамж
4. **Цэнэглэлт.** Хэрэглэгчийн картыг цэнэглэх олон боломжтой байх.

Системийн шийдэл нь мэдээллийг нэгдсэн нэг газар төвлөрүүлэн УХААЛАГ УС ТҮГЭЭГҮҮР-ийн технологи, үйл ажиллагааг алсаас удирдах, засварлах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

- Хэрэглэгч илүү хялбар, хурдан найдвартай аргаар ус авах
- 24 цагийн ажиллагаатай байх
- Хэрэглэгчид зориулсан төлбөрийн системтэй байх
- Хэрэглэгчдийн ус авалтын мэдээлэл болон орлого зарлагын нэгдсэн тайлан гардаг байх
- Хяналт, мониторингийн системтэй байх
- Ус борлуулалтын нэгдсэн цахим мэдээллийн сан үүсгэх

Мэдээллийн нэгдсэн сан дараах хэсгүүдээс бүрдэнэ:

#### Online server:

Хэрэглэгчийн ерөнхий мэдээлэл, дансны мэдээлэл, банкны холболт, хэрэглээний мэдээлэл зэргийг бүртгэж, хадгалж, засварлаж шинэчлэх систем. Ус түгээгүүр бүрийн ажиллагааны төлөвийг шалгаж түүн дээрээ үндэслэн аль түгээгүүрт ямар мэдээлэл хүргэх, түгээгүүрээс ямар мэдээлэл ирсэн зэргийг бүртгэж авах цогц удирдлагын систем байна.

#### Ус түгээгүүрийн систем:

УТБайр дээр суурилагдсан бүх үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийг удирдаж ажиллана.

**Системийн шинэчлэл:** УТБ болгоноор биечлэн очилгүйгээр системийн шинэчлэлийг хийх боломжтой байх.



## Суурилагдах төхөөрөмжүүд

### Гадаа хайрцаг

- Ус дотогш нэвтрэхээс хамгаалсан байх ёстой
- Гаднаасаа онгойлгох боломжгүй байх
- Бат бөх 1.5мм ийн зузаантай ЛИСТ төмөрөөр хийгдсэн байх
- Суурилагдсан байгаа төхөөрөмжүүд гаднаасаа авах боломжгүй зөвхөн дотор талаасаа авах боломжтой байна

### LED дэлгэц

LED дэлгэц нь халуун хүйтэнд тэсвэртэй, тасралтгүй удаан ажиллахад зориулагдсан байна, хэрэглэгчид мэдээлэл хүргэх зориулалттайгаар өнгөт LED дэлгэц байх ёстой

- RGB технологиор асдаг буюу өнгөт дэлгэц. Зураг, Video гаргах боломжтой.
  - Гадна ажиллах боломжтой
  - Дэлгэцийн хэмжээ 100мм x 200мм.
- Keypad :

### Гар / keypad/

Олон улсын IP55 стандартын гадна зориулалттай төмөр гадаргуутай, ус нэвтэрдэггүй, гэрэлтэй байх.

### Карт уншигч

NFC chip тэй карт унших зориулалт бүхий уншигч төхөөрөмж. Төхөөрөмж нь картын дугаарыг уншин удирдлагын төхөөрөмж рүү дамжуулна. 5V ийн хүчдэлээр ажиллана.

### Гэрэлтүүлэг

Гэрэлтүүлэг нь гадна хэсгийг гэрэлтүүлдэг байх ёстой. Цагийн тохиргоо хийгддэг байх.

### Камер

Камер нь гадна ажиллахад зориулагдсан олон улсын чанарын IP65 стандартыг хангах, өдөр шөнийн бичлэг хийдэг камер тавигдана.

Бичлэг бичигч төхөөрөмж нь 30 хоног бичлэг хадгалах санах ойтой, 24цаг тасрастгүй ажиллах горимтой хийгдсэн байх.

### Усны тоолуур буюу Урсац хэмжигч.

Олон улсын стандартыг хангасан бүтээгдэхүүн байх, стандартчилал хэмжил зүйн төвийн зөвшөөрөлтэй байх.

### Автомат хаалт 2 ширхэг

Олон улсын стандартыг хангасан бүтээгдэхүүн. Үндсэн ус гаралт болон ус алдалтын үед ашиглах автомат хаалт байх ёстой. Автомат удирдлагатай байх.

### Модем

3G модем хэрэглэнэ.3G болон 2G сүлжээнд ажилладаг байх. Дата сим ашиглан төв сервертэй холбогдох, мэдээлэл дамжуулах.

### Тог баригчтай байх

Цахилгаан тасарсан тохиолдолд системийг 2 цаг тасралтгүй ажиллагааг хангах ёстой.

### **Sensor, дэлгэц удирдлагын процессор**

Энэ процессор нь програмчлах зориулалт бүхий жижиг хэмжээний модуль байна. Мэдрэгч, дэлгэц бусад автоматикийн бүрдлийг удирддаг байх




### **Удирдлагын процессор**

Удирдлагын процессор нь Raspberry Pi3 байна.

Хүчин чадал

- A 900MHz quad-core ARM Cortex-A7 CPU
- 1GB RAM
- 4 USB ports, 40 GPIO pins
- Full HDMI port
- Ethernet port
- Combined 3.5mm audio jack and composite video
- Camera interface (CSI)
- Display interface (DSI)
- Micro SD card slot
- VideoCore IV 3D graphics core



### **Сантехникийн холболт / PPR материалаар хийх/**

Үндсэн орж ирж байгаа шугамаас огтолгоо авч хаалт тавин төхөөрөмжүүдээ холбоно. Холболтыг PPR материалаар хийнэ. /Ашиглагч байгууллагын хяналт дор худаг бүрийн сантехник угсралтыг хийх/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт, тайлбар	Тоо хэмжээ
1	Товчлуур	Усны хэмжээ оруулах 10 цифртэй, НЭЭХ болон ХААХ товчтой, код оруулах	1 иж бүрдэл
2	Удирлагын нэгдсэн төв процессор	Системийг удирдаж нэгдсэн удирдлагын сервертэй мэдээлэл солилцоно, RASPBERRY	
3	Төхөөрөмж удирдлагын процессор	Тоолуур, Автомат хаалт удирдах схем	
4	Автомат хаалт	Усны автомат хаалт	
5	Тоолуур	1 литр тутам мэдээлэл дамжуулах импульсын гаралттай тоолуур	
6	Карт уншигч	NFC card reader	
7	Дэлгэц	LED гэрлэн дэлгэц	
8	Гадна хайрцаг	Уснаас хамгаалагдсан	
9	Удирлагын хайрцаг	сүлжээний төхөөрөмж, камерын бичлэг бичих төхөөрөмж, процессор, удирдлагын плат, модем байрлана	
10	Camera	IP Camer, Pixel 2M	
11	Бичлэг хийх төхөөрөмж	30 хоног бичлэг хийх боломжтой	
12	HDD	Бичлэг хадгалах диск	
13	Тог баригч UPS	2 цаг тасралтгүй тэжээлээр хангах	
14	Хэрэглэгчийн карт	NFC card	
15	LED гэрэлтүүлэг	Ус авах талбайг гэрэлтүүлэх	
16	Сангийн материал	Худаг дээр хийгдэх сангийн ажлын материал, PPR материал	
17	3G Modem	GSM, 3G модем	
18	Программ хангамж	Нэгдсэн системд холбогдох, худгийн автомат системийг удирдах програм хангамж	
19	Суурилуулалт		
20	Тээвэр, татвар		



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ 1**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар, тээврийн болон суурьлуулах бусад бүх зардал	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО  
ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

**МАЯГТ 3**

№	Дотоодод үйлдвэрлэсэн бараа, материалын нэр	Хэмжих нэгж	Нийт хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Тайлбар
1						
2						
.						
.						
.						
	Нийт дүн					

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>/тоо/</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |



## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага **12 сар**
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,5%-7 хоногт]**
- Алдангийн нийт дүн: **[ 20%]**

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*